



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Цагдаагийн газрын  
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** БУА-2026/30/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.open.audit.mn">www.open.audit.mn</a></p> <p>Булган аймаг 2026 он</p>	<p>Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Батцогт Утас: 7034-2580 Цахим хаяг: <a href="mailto:Battsogtd@audit.gov.mn">Battsogtd@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Цахим хаяг: <a href="mailto:Enkhtsoodolj@audit.gov.mn">Enkhtsoodolj@audit.gov.mn</a></p> <p>Ахлах аудитор: Д.Анхбаяр Цахим хаяг: <a href="mailto:Ankhubayard@audit.gov.mn">Ankhubayard@audit.gov.mn</a></p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Нэг. Аудитын санал дүгнэлт



### БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,  
63082, Утас/Факс: 7034-2580

Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2025.02.24 № 134

танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

АЙМГИЙН ЦАГДААГИЙН ГАЗРЫН  
ДАРГА Б.ЭРДЭНЭБИЛЭГ ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн Цагдаагийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон тэмдэглэсэн хэсэг

Улсын төсөвт шинээр баригдах конторын барилгыг төсөв тусгасан, Эрүүлжүүлэх, саатуулах байрны барилгын ТЭЗҮ-ийг шинээр гаргуулсан байна.

Аймгийн Цагдаагийн газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилт, 51 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 91 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

#### Аудитын гол асуудал

Тус Цагдаагийн газрын дотоодын журмыг боловсруулан нийт бие бүрэлдэхүүнд танилцуулж хэлэлцүүлснээр Цагдаагийн газрын даргын 2025 оны 07 дугаар сарын 09 өдрийн А/56 дугаартай тушаалаар байгууллагын дотоод журмыг 10 зүйл 84 заалттай шинэчлэн баталж үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна.

#### Бусад асуудал

6326050080

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТЦОГТ

## Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

(мянган төгрөгөөр)

	Үзүүлэлт	2024.12.31.	2025.12.31.
<b>Санхүүгийн байдлын тайлан</b>			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	264,382.49	463,641.98
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,486,540.01	2,765,220.60
	<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>2,918,477.55</b>	<b>3,396,417.63</b>
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,918,477.55	3,396,417.63
	<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>2,918,477.55</b>	<b>3,396,417.63</b>
<b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>			
	Үйл ажиллагааны орлогын дүн	6,548,893.08	7,661,784.08
	Үйл ажиллагааны зардлын дүн	5,921,281.04	7,182,356.50
	<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>627,612.03</b>	<b>479,427.76</b>
	Үйл ажиллагааны бус үр дүн	(64,183.14)	(1,221.38)
	<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>563,428.88</b>	<b>477,940.08</b>
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,355,339.29	2,918,477.55
	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	(966.06)	
	Тайлант оны үр дүн	564,104.32	477,940.08
	<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>2,918,477.55</b>	<b>3,396,417.63</b>
<b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	5,825,005.83	7,030,586.46
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	5,768,916.53	7,015,854.18
	<b>Үйл ажиллагааны ЦМГ</b>	<b>56,089.30</b>	<b>14,732.28</b>
	<b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>	<b>(47,680.00)</b>	<b>(50,254.80)</b>
	<b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>	<b>-</b>	<b>-</b>
	<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>8,409.29</b>	<b>14,732.28</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	27,113.22	35,522.51
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	35,522.51
<b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>			
	<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>-</b>	<b>6,823,100.49</b>
	Урсгал зардал	-	6,823,100.49
	Хөрөнгийн зардал	-	-
	<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>	<b>-</b>	<b>6,823,100.49</b>
	Улсын төсвөөс санхүүжих	-	6,822,634.19
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	466.30

### Гурав. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Аймгийн Цагдаагийн газар /цаашид ЦГ/ нь “Хүний эрхийг дээдлэн, шударга ёсыг эрхэмлэж амар тайван нийгмийг бүрдүүлнэ”, “Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүрэгтэй” гэсэн эрхэм зорилго, зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулжээ.

Байгууллагын зохистой засаглал, дотоод хяналтын байдал, төсөв санхүүгийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, эрсдэлийн удирдлагаар хангах үндсэн дээр байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх үндсэн ажиллагааны хэрэгжүүлэн ажилласан байна.

### **Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Цагдаагийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Шилэн дансны хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль болон бусад хууль, тогтоомжууд, эрх зүйн актуудыг мөрдлөг болгон ажилласан байна.

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуульд *2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан, Цагдаагийн албан тухай хуульд 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан байна.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **Дөрөв. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Улсын төсөвт шинээр баригдах конторын барилгыг төсөв тусгасан, Эрүүлжүүлэх, саатуулах байрны барилгын ТЭЗҮ-ийг шинээр гаргуулсан байна.

Аймгийн Цагдаагийн газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилт, 51 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 91 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

### **Тав. Аудитын гол асуудал**

Тус Цагдаагийн газрын дотоодын журмыг боловсруулан нийт бие бүрэлдэхүүнд танилцуулж хэлэлцүүлснээр Цагдаагийн газрын даргын 2025 оны 07

дугаар сарын 09 өдрийн А/56 дугаартай тушаалаар байгууллагын дотоод журмыг 10 зүйл 84 заалттай шинэчлэн баталж үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна.

### **Зургаа. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

#### **Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2-15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалтыг хэрэгжүүлээгүй, цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна.

#### **Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Батлагдсан төсөв жилээр мэдээллэх шилэн дансны 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3. "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20.5. "Энэ хуулийн 3.1-д заасан этгээд Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулна" гэсэн заалтуудыг тус тус зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэв.

#### **Долоо. Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

#### **Найм. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 3,452.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 3,452.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгч ажиллалаа.

#### **Төлбөрийн акт**

Төлбөрийн акт тогтоогоогүй

#### **Албан шаардлага**

Албан шаардлага өгөөгүй.

### **Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Түлш, шатах тослох материалын анхан шатны баримт дутуу байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйл, Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын хавсралт "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам" болон үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Зөрчлийг давтан гаргахгүй байх

Дээрх төлбөрийн акт болон зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дугаар сарын 10-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	А.Т тоо	Тоо	Дүн	
Түлш, шатах тослох материалын анхан шатны баримт дутуу байна.	1	3,452.0					1	3,452.0					
Дүн	1	3,452.0					1	3,452.0	-	-	-	-	-

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Батлагдсан төсөв жилээр мэдээллэх шилэн дансны 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	0					1	0
Дүн	1	0					1	0